

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2008 оны 5 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 286

Улаанбаатар хот

Журам, заавар, ажлын хэсгийн бүрэлдэхүүн,
жагсаалт батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8, 9 дүгээр зүйл, 15 дугаар зүйлийн 15.1, 25 дугаар зүйлийн 25.1.10, “Онцгой байдлын ерөнхий газрын дотоод журам”-ын 6.3, Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Шуурхай ажиллагааг зохион байгуулах журам”-ыг 1 дүгээр, “Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн ажиллах заавар”-ыг 2 дугаар, “Шуурхай ажлын хэсгийн бүрэлдэхүүн”-ийг 3 дугаар, “Гамшгийн мэдээлэл солилцох бүдүүвч”-ийг 4 дүгээр, “Шуурхай ажиллагаанд хөтлөгдөх баримт бичиг”-ийг 5 дугаар, “Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн ажлын байранд байх эрх зүйн баримт бичиг”-ийг 6 дугаар, “Шуурхай ажиллагаанд ашиглах холбоо, мэдээллийн техник хэрэгслийн жагсаалт”-ыг 7 дугаар хавсралтын ёсоор баталсугай.

2. “Шуурхай ажиллагааг зохион байгуулах журам”, “Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн ажиллах заавар”-ыг мөрдөж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, харъяа салбар нэгж, нийт бие бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Батлагдсан журам, зааврыг үндэслэн аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Онцгой байдлын газар, хэлтсийн шуурхай ажиллагааг зохион байгуулах журмыг орон нутгийн онцлогийг харгалзан боловсруулж мөрдөхийг аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга нарт даалгасугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд дарга бөгөөд Гамшигтай тэмцэх газрын дарга комиссар Д.Намсрайд даалгасугай.

5. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2004 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 442, 2005 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 295, 2006 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 175, 4 дүгээр сарын 7-ны өдрийн 178, 5 дугаар сарын 26-ны өдрийн 260, 7 дугаар сарын 21-ний өдрийн 354, 8 дугаар сарын 14-ний өдрийн 387 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА
ТЭРГҮҮН КОМИССАР

Ц.АМГАЛАНБАЯР

ШУУРХАЙ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8, 9 дүгээр зүйл, 15 дугаар зүйлийн 15.1, 25 дугаар зүйлийн 25.1.10-т заасныг хэрэгжүүлэх, Онцгой байдлын ерөнхий газраас улсын хэмжээнд гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, учирсан хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах, өдөр тутмын нөхцөл байдлын удирдлага, зохицуулалтаар хангах, мэдээлэл солилцох, шуурхай ажиллагааг зохион байгуулах арга хэмжээг энэ журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмыг Онцгой байдлын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, харъяа салбар, нэгж дагаж мөрдөнө.

1.3. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно:

1.3.1. “шуурхай ажиллагаа” гэж онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн алба, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай мэдээг нэгтгэн цуглуулж, үнэлгээ, дүгнэлт хийх, удирдлагыг мэдээллээр тасралтгүй хангах, удирдлагаас гаргасан шийдвэрийг тухайн байгууллагад хүргэж, биелэлтийг зохион байгуулах цогц үйл ажиллагааг;

1.3.2. “албаны өндөржүүлсэн бэлэн байдал” гэж гамшгийн нөхцөл байдал үүссэн болон үүсч болзошгүй нөхцөлд зөвхөн онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэхийг;

1.3.3. “шуурхай ажлын хэсэг” гэж гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдал зарласан үед гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг шуурхай удирдлагаар хангах, гамшгаас хамгаалах улсын алба, байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэгтэй мэргэжлийн бүрэлдэхүүнийг;

1.3.4. “ерөнхий эргүүл” гэж баяр, амралтын болон гамшгийн нөхцөл байдал үүсч болзошгүй үед Онцгой байдлын ерөнхий газар, харъяа салбар, нэгжийн үйл ажиллагаа, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах арга хэмжээнд хяналт тавьж, үүрэг гүйцэтгэх албан тушаалтныг;

1.3.5. “шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч” гэж өдөр тутмын бэлэн байдлын үед шуурхай ажиллагааг зохион байгуулахаар 24 цагийн турш үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчийг.

Хоёр. Шуурхай ажиллагааны зохион байгуулалт

2.1. Улсын хэмжээнд гамшгийн нөхцөл байдлын шуурхай удирдлага, зохицуулалтыг гамшгаас хамгаалах өдөр тутмын бэлэн байдлын үед Онцгой байдлын ерөнхий газрын шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч, өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын үед Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар томилсон шуурхай ажлын хэсэг хэрэгжүүлнэ.

2.2. Шуурхай ажлын хэсгийг өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед нэгжийн дарга, шуурхай удирдлага, зохицуулалтын нэгжийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, бүх нийтийн бэлэн байдал зарласан үед зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргаар ахлуулан ажиллуулна.

2.3. Гамшгийн аюул үүссэн буюу үүсч болзошгүй нөхцөл байдлын үед болон баяр, амралтын өдөр Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар ерөнхий эргүүл томилон ажиллуулж болно.

2.4. Гамшгийн нөхцөл байдал үүссэн болон үүсч болзошгүй нөхцөлд Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хүрээнд, аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Онцгой байдлын газар, хэлтсийн даргын тушаалаар орон нутгийн хүрээнд албаны өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлнэ.

2.5. Хоёр болон түүнээс дээш аймгийн нутаг дэвсгэрт энэ журмын 2.4-т заасан нөхцөл үүссэн үед Засгийн газраас шийдвэр гараагүй тохиолдолд Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар хэсэгчилсэн байдлаар аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Онцгой байдлын газар, хэлтсийг албаны өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлнэ.

2.6. Онцгой байдлын ерөнхий газрын “Цонхлон” радио станцын оператор нь шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчид шууд захирагдаж шуурхай ажиллагааны холбооны техник хэрэгслийн ашиглалт, холбоо зохион байгуулалтыг хариуцсан туслахын үүрэг гүйцэтгэх бөгөөд үйл ажиллагаандаа “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын холбоо зохион байгуулж, ашиглах журам”-ыг мөрдөж ажиллана.

2.7. Шуурхай ажлын хэсэг, шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч, туслах нь албан үүргээ биелүүлэх нөхцөл боломж, техник хэрэгслээр хангагдсан ажлын байранд үүрэг гүйцэтгэнэ.

2.8. Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч, туслах нь үүрэг гүйцэтгэх үедээ хоногт 2 цагаас илүүгүй хугацаагаар, ээлжлэн амрахыг зөвшөөрнө.

2.9. Гамшгийн аюул үүссэн болон үүсч болзошгүй нөхцөл байдлын үед болон зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгүүлэх болсон тохиолдолд Онцгой байдлын ерөнхий газрын дарга, дэд дарга, гамшгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргын шийдвэрээр тухайн үед үүрэг гүйцэтгээгүй амарч байгаа шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийг ажиллуулна.

2.10. Шуурхай ажлын хэсэг, шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн ажлын байранд Онцгой байдлын ерөнхий газрын дарга, дэд дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн болон шуурхай удирдлага, зохицуулалтын нэгжийн дарга, шуурхай ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтнээс өөр албан тушаалтан, гадны хүн орохыг хориглоно.

2.11. шуурхай ажиллагааны холбоо мэдээллийн техник хэрэгслийг зөвхөн гамшгаас хамгаалах шуурхай удирдлага, зохицуулалтын мэдээ, мэдээлэл, дамжуулах, хүлээн авахад ашиглах ба өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

Гурав. Шуурхай ажиллагааны удирдлага

3.1. Шуурхай ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь ажлын хэсгийн ахлагчид захирагдах бөгөөд ажлын хэсгийн ахлагч, ерөнхий эргүүл нь Онцгой байдлын ерөнхий газрын дарга, дэд даргад захирагдана.

3.2. Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга бөгөөд Гамшигтай тэмцэх газрын дарга шуурхай ажлын хэсэг, ерөнхий эргүүлийг удирдлагаар хангаж ажиллана.

3.3. Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч, туслах нь шуурхай удирдлага, зохицуулалтын нэгжийн даргад захирагдах бөгөөд шуурхай ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн нь өдөр тутмын үйл ажиллагааг шууд удирдлагаар хангаж ажиллана.

Дөрөв. Аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Онцгой байдлын газар, хэлтэс,
Аврах тусгай ангийн шуурхай ажиллагааны удирдлага, зохион байгуулалт

4.1. Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, Онцгой байдлын ерөнхий газарт шуурхай ажлын хэсэг томилогдон ажиллах үед гамшгийн нөхцөл байдал үүссэн аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Онцгой байдлын газар, хэлтэст шуурхай ажлын хэсэг томилон ажиллуулна.

4.2. Шуурхай ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг гамшгийн нөхцөл байдлаас шалтгаалан аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга, Аврах тусгай ангийн захирагчийн тушаалаар томилно.

4.3. Шуурхай ажлын хэсгийг Аврах тусгай ангид штабын дарга, нийслэлийн Онцгой байдлын газарт газрын орлогч, хэлтсийн дарга, аймгийн Онцгой байдлын хэлтэст гамшгаас хамгаалах хяналтын улсын байцаагч, тасаг, анги, салбарын даргаар ахлуулан ажиллуулна.

4.4. Шуурхай ажлын хэсгийн ахлагч, шуурхай удирдлагын зохицуулагч нь тухайн нутаг дэвсгэрт гамшгийн аюул үүссэн буюу үүсч болзошгүй нөхцөл байдал бий болсон үед аймаг, нийслэл /дүүрэг/-ийн газар, хэлтсийн даргад яаралтай илтгэж, шуурхай ажиллагааг зохион байгуулна.

4.5. Шуурхай ажлын хэсэг, шуурхай удирдлагын зохицуулагчийг аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга, Аврах тусгай ангийн захирагч шууд удирдлагаар хангаж ажиллана.

4.6. Шуурхай ажлын хэсэг гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх үед орон тооны холбоочинг томилж “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын холбоо зохион байгуулж, ашиглах журам”-ын дагуу холбоог зохион байгуулах ба байршил тодорхойлогч (GPS)-ийг ашиглана.

4.7. Шуурхай ажлын хэсэг болон аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Онцгой байдлын хэлтэс, газрын дарга нар гамшгийн нөхцөл байдал үүссэн газар орны байршлыг байршил тодорхойлогч (GPS)-ийг ашиглан тодорхойлж, гамшгийн тухай мэдээллийг тухайн газар орны координатын хамт солилцоно.

4.8. Аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Онцгой байдлын газар, хэлтэс, Аврах тусгай анги, Шуурхай ажлын хэсэг гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх үед ашиглах үүрэн телефон холбооны ярианы цэнэглэгч картыг бэлэн байлгах ба зарцуулалтад хяналт тавьж, нөхөн бүрдүүлнэ.

4.9. Аймгийн Онцгой байдлын хэлтсийн дуудлага хүлээн авагч нь шуурхай удирдлагын зохицуулагчийн туслахын үүрэг гүйцэтгэх бөгөөд шуурхай удирдлагын зохицуулагчид захирагдана.

4.10. Өдөр тутмын бэлэн байдлын үед шуурхай удирдлагаар хангах үүргийг нийслэлийн Онцгой байдлын газарт шуурхай зохицуулалтын мэргэжилтэн, Аврах тусгай ангид ангийн жижүүр, аймгийн Онцгой байдлын хэлтэст тухайн өдөр ээлжинд үүрэг гүйцэтгэж буй салааны захирагч хавсран гүйцэтгэнэ.

4.11. Аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга нар өөрсдийн ашиглаж байгаа холбооны сүлжээг ашиглан гамшгийн нөхцөл байдал үүсч болзошгүй болон үүссэн үед тухай бүрт нь, бусад үед өдөрт 1-ээс доошгүй удаа гамшгаас хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, гамшгийн нөхцөл байдлын талаар Онцгой байдлын ерөнхий газрын шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчид биечлэн мэдэгдэнэ.

4.12. Аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга эмнэлгийн чөлөөтэй, ээлжийн амралт, чөлөө авсан болон гамшгийн нөхцөл байдал, ажлын шаардлагаар түр эзгүй байх үедээ орлох албан тушаалтныг томилон Онцгой байдлын ерөнхий газрын шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчид мэдэгдэнэ.

4.13. Гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг зохион байгуулахад тухайн орон нутаг дахь хүч хэрэгсэл хүрэлцэхгүй байгаа бөгөөд нэмэгдэл хүч хэрэгсэл шаардлагатай байгаа тухай санал тавьсан тохиолдолд Онцгой байдлын ерөнхий газрын дарга, дэд даргын шийдвэрээр Аврах тусгай ангиар үүрэг гүйцэтгүүлнэ.

4.14. Аврах тусгай ангиар үүрэг гүйцэтгүүлэх тухай Онцгой байдлын ерөнхий газрын дарга, дэд даргын шийдвэрийг Онцгой байдлын ерөнхий газрын шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчаар дамжуулан Аврах тусгай ангийн жижүүрт мэдэгдэнэ.

Тав. Шуурхай ажлын хэсгийн үйл ажиллагаа

5.1. Гамшгийн аюул үүссэн буюу үүсч болзошгүй нөхцөл байдлын үед Шуурхай ажлын хэсэг /цаашид “ажлын хэсэг” гэх/-ийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэрээр ажиллуулна.

5.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах хугацааг тухайн гамшгийн аюулын нөхцөл байдал, онцлог, цар хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээ зэргийг

харгалзан тогтооно. Шаардлагатай үед Онцгой байдлын ерөнхий газрын бусад зохион байгуулалтын бүтцийн нэгжийн ажилтныг ажиллуулж болно.

5.3. Ажлын хэсэг нь гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг улсын хэмжээнд шуурхай удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.

5.4. Ажлын хэсэг нь энэ журмын 4.3-т заасныг хэрэгжүүлэхдээ гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн албад, нутгийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Онцгой байдлын газар, хэлтсийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд нь хяналт тавин ажиллана.

5.5. Ажлын хэсгийг ажиллах нөхцөл бололцоо, шаардлагатай техник, хэрэгслээр хангагдсан ажлын байранд ажиллуулна. Шаардлагатай үед ажлын хэсгийн ажлын өрөөг нэмэлт техник, тоног төхөөрөмжөөр тоноглож болно.

5.6. Ажлын хэсгийн ашиглаж байгаа эд аж ахуй, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг үүрэг гүйцэтгэж буй ажлын хэсгийн ахлагч, бусад үед шуурхай ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн хариуцна.

Зургаа. Ерөнхий эргүүлийн үйл ажиллагаа

6.1. Ерөнхий эргүүл нь гүйцэтгэсэн үүрэг, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Онцгой байдлын ерөнхий газрын дарга, дэд дарга бөгөөд Гамшигтай тэмцэх газрын даргад бичгээр танилцуулж, дараагийн эргүүлд анхаарвал зохих асуудал болон удирдлагаас өгсөн үүргийг мэдэгдэж хүлээлцэнэ.

6.2. Ерөнхий эргүүл нь Онцгой байдлын ерөнхий газрын шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч болон аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Онцгой байдлын газар, хэлтэс, харъяа салбар, нэгжийн гамшгаас хамгаалах талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд хяналт тавьж, удирдлагаас өгсөн үүргийг биелүүлж ажиллана.

6.3. Ерөнхий эргүүлд Онцгой байдлын ерөнхий газрын харъяа салбар, нэгж, тухайн өдөр үүрэг гүйцэтгэж буй жижүүрлэлтийн бүрэлдэхүүн шууд захирагдана.

Долоо. Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн үйл ажиллагаа

7.1. Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч нь улсын хэмжээнд тухайн өдөр гарсан гамшгийн нөхцөл байдлыг шуурхай удирдлага, зохицуулалтаар хангаж, “Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн ажиллах заавар”-ыг мөрдөж ажиллах бөгөөд дараах эрх, үүрэгтэй байна.

7.1.1. Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн эрх:

7.1.1.1. гамшгаас хамгаалах талаар удирдлагын өгсөн үүргийг аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга, холбогдох албан тушаалтанд дамжуулах, биелэлтэд нь хяналт тавих, гамшгийн нөхцөл байдлын талаар шаардлагатай мэдээллийг гаргуулан авах;

7.1.1.2. Онцгой байдлын ерөнхий газар, харъяа салбар, нэгжийн хоногийн жижүүрлэлтийн бүрэлдэхүүнд шуурхай удирдлага, зохицуулалтыг хангах асуудлаар үүрэг, чиглэл өгөх, шаардлага тавих.

7.1.2. Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн үүрэг:

7.1.2.1. гамшгийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл, хэрэгжүүлсэн арга хэмжээ, дүгнэлтийг хоногийн нөхцөл байдлын мэдээнд бүрэн тусгах;

7.1.2.2. хоногийн нөхцөл байдлын мэдээг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, дэд дарга, гамшгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн болон шуурхай удирдлага, зохицуулалтын нэгжийн дарга, шуурхай ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн нарт танилцуулж, удирдлагаас өгсөн үүргийг холбогдох албан тушаалтанд мэдэгдэх;

7.1.2.3. гамшгийн нөхцөл байдал үүссэн үед анхны цагийн байдалд үнэлгээ дүгнэлт өгч, гамшгийн үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, зааврын дагуу шийдвэр гарган шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах, энэ тухай Онцгой байдлын ерөнхий газрын удирдлагад тухай бүрт нь илтгэх;

7.1.2.4. гамшгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Шуурхай ажиллагааны журналд тухай бүрт нь тэмдэглэх;

7.1.2.5. гамшгийн нөхцөл байдлын талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Шуурхай мэдээллийн алба, Засгийн газрын Шуурхай жижүүрт тогтоосон цагт мэдээлж, мэдээлэл солилцох, гамшгийн аюул үүссэн буюу үүсч болзошгүй нөхцөл байдал бий болсон үед тухайн бүрт нь мэдэгдэх;

7.1.2.6. баяр, амралтын өдөр, ажлын бус цагаар хойшлуулшгүй яаралтай ажлын үед олгох албан томилолтын үнэмлэх, зардал /зам хоног, байрны зардал, автомашины шатахуун, суурин болон хөдөлгөөнт холбооны урьдчилсан төлбөрийн хэрэгсэл/-ыг олгож, энэ тухай акт бичиж, санхүүтэй тооцоо хийх;

7.1.2.7. ажил хүлээлцэхдээ дараагийн шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчид онцлон анхаарах, тодотгох асуудал, удирдлагаас өгсөн үүргийг танилцуулж, энэ тухай шуурхай ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэнд илтгэх;

7.1.2.8. гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүнтэй тасралтгүй холбоотой ажиллаж, нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээллээр удирдлагыг бүрэн хангах;

7.1.2.9. шаардлагатай үед удирдлагын шийдвэрийн дагуу “Яаралтай цуглар” дохио өгч, цугларалтын байдалд хяналт тавьж, ирцийг бүртгэх;

7.1.2.10. үүрэг гүйцэтгэх хугацаанд ажлын өрөөний эд хогшил болон техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцах.

7.2. Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч, туслахын үйл ажиллагаанд хориглох зүйл:

7.2.1. шалтгаангүйгээр ажлын байрыг дур мэдэн орхих;

7.2.2. ажлын өрөөнд зөвшөөрөгдсөнөөс бусад хүнийг нэвтрүүлэх;

7.2.3. шуурхай удирдлага, зохицуулалтын зориулалт бүхий техник хэрэгслийг зориулалтын бусаар ашиглах, бусдад ашиглуулах.

7.2.4. хоногийн нөхцөл байдлын мэдээнд тусгагдсан гамшгийн нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээллийг удирдлагын зөвшөөрөлгүй буюу хэвлэл, олон нийттэй харилцах нэгжээр дамжуулалгүй хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгөх.

Найм. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчийн нийтлэг үүрэг:

8.1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагч нь гамшгаас хамгаалах арга хэмжээг шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр дараах үүргийг хүлээнэ:

8.1.1. гамшгийн аюул үүссэн болон үүсч болзошгүй нөхцөл байдлын тухай авсан мэдээ, мэдээллийнхээ талаар Онцгой байдлын ерөнхий газрын шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчид, орон нутагт тухайн аймгийн Онцгой байдлын хэлтсийн шуурхай удирдлагын зохицуулагчид яаралтай мэдэгдэх;

8.1.2. Онцгой байдлын ерөнхий газрын албан тушаалтан нь ажлын бус цагаар болон баяр, амралтын өдөр хойшлуулшгүй яаралтай ажлын шаардлага гарсан үед холбоо барих утасны дугаар, гэрийн хаягаа тодорхой байлгах, хаяг өөрчлөгдсөн тохиолдолд шуурхай ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэнд тухай бүрт нь мэдэгдэн тодотгол хийлгэх.

8.2. Гамшгаас хамгаалах арга хэмжээний шуурхай ажиллагааг хангах зорилгоор онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагч нарт дараах зүйлийг хориглоно:

8.2.1. зөвшөөрөгдсөнөөс бусад албан тушаалтан шуурхай ажлын хэсэг, шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн өрөөнд орох, үүрэг гүйцэтгэхэд нь саад болох;

8.2.2. шуурхай ажиллагааг зохион байгуулахтай холбоогүй ажил болон ажлын бус цаг, баяр, амралтын өдрөөс бусад үед шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчаар албан тушаалтныг дуудуулах, дуудахыг шаардах;

8.2.3. шуурхай удирдлагын жижүүрийн үүрэг гүйцэтгэж буй албан хаагчаас үүрэгт ажилд нь хамааралгүй өөр ажил, үүрэг гүйцэтгэхийг шаардах;

8.2.4. шуурхай ажил /жижүүр/-ын автомашиныг зориулалтын бус ажилд хэрэглэх;

Ес. Бусад зүйл

9.1. Шуурхай ажлын хэсэг, ерөнхий эргүүл томилогдон ажиллаж байгаа үед болон баяр, амралтын өдрүүдэд шуурхай ажил /жижүүр/-ын автомашин, жолоочийг томилон ажиллуулах бөгөөд Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Хангалт, үйлчилгээний анги хариуцан зохион байгуулна.

9.2. Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч нь Хангалт, үйлчилгээний ангийн харуул манааны үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчийн үүрэг гүйцэтгэлийн байдалд хяналт тавина.

9.3. Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч, туслахад хоолны зардлыг олгохдоо Онцгой байдлын ерөнхий газрын дотоод журамд заасны дагуу олгодог нэг өдрийн хоолны зардлын хэмжээг 3 дахин өсгөж, ажилдаа ирэх, буцах унааны зардлыг үүрэг гүйцэтгэсэн өдрөөр тооцон олгоно.

9.4. Шуурхай ажлын хэсгийн бүрэлдэхүүн /шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчаас бусад/-д хоолны зардал олгохдоо Онцгой байдлын ерөнхий газрын дотоод журамд заасны дагуу олгодог хоолны зардлын хэмжээг 2 дахин өсгөж олгоно.

9.5. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд Гамшгаас хамгаалах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, "Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчийн сахилгын дүрэм"-д заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ооо

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2008 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн
286 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ШУУРХАЙ УДИРДЛАГЫН ЕРӨНХИЙ ЗОХИЦУУЛАГЧИЙН АЖИЛЛАХ ЗААВАР

Нэг. Өдөр тутмын бэлэн байдлын үед:

1.1. Өмнөх шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн хоногийн нөхцөл байдлын мэдээ, тойм зураг, удирдлагаас өгсөн үүргийг судлан хэрэгжүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавих.

1.2. Аймаг, нийслэл /дүүрэг/-ийн гамшгаас хамгаалах алба, улсын албадаас цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан тохиолдож болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх талаар хийж байгаа ажлын тухай мэдээллийг авч нэгтгэх, тэдгээрийг өөрийн эрх мэдлийн хүрээнд үүрэг зөвлөмжөөр хангах.

1.3. Гамшгаас хамгаалах улсын алба, төрийн болон нутгийн захиргаа, аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах бэлэн байдлыг тодотгож, хяналт тавьж ажиллах.

1.4. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс тавьж буй асуудлыг хүлээн авч өөрийн эрх мэдлийн хүрээнд болон холбогдох албан тушаалтанд мэдэгдэж хариу өгөх.

1.5. Хоногийн нөхцөл байдлын мэдээнд байгууллага, улсын албадын гамшгаас урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, шийдвэрлэсэн асуудал, өгсөн үүрэг, зөвлөмж, тулгамдсан асуудлыг бүрэн тусгаж, удирдлагад илтгэх.

1.6. Гамшгийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Шуурхай мэдээллийн алба, Засгийн газрын Шуурхай жижүүр, Тагнуулын ерөнхий газрын оперативийн жижүүр болон холбогдох улсын албадтай солилцох.

1.7. Дараагийн шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчид онцлон анхаарах, тодотгох асуудал, удирдлагаас өгсөн үүргийг танилцуулах.

1.8. Гамшгийн тухай эх сурвалжаас нь /хэзээ, хаана, ямар нөхцөл байдал үүссэн, авч байгаа арга хэмжээний талаар/ тодотгож, тухайн асуудлаар тодорхой ойлголт авч дүгнэлт хийсний үндсэн дээр Онцгой байдлын ерөнхий газрын дарга, дэд дарга, гамшгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж болон шуурхай удирдлага, зохицуулалтын нэгжийн дарга, холбогдох албан тушаалтан (мэргэжилтэн), улсын алба (байгууллага)-д илтгэж танилцуулах, өгсөн үүргийг хэрэгжүүлэх, биелэлтийн талаар хариу мэдэгдэх.

Хоёр. Өндөржүүлсэн бэлэн байдал болон Бүх нийтийн бэлэн байдлын үед:

2.1. Газар хөдлөлтийн үед

2.1.1. газар хөдлөлт болсон тухай Онцгой байдлын ерөнхий газрын дарга, гамшгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж болон шуурхай удирдлага, зохицуулалтын нэгжийн дарга, холбогдох албан тушаалтан (мэргэжилтэн), улсын алба (байгууллага)-д илтгэж, өгсөн үүргийг гүйцэтгэгчид мэдэгдэж хэрэгжилтэд нь хяналт тавих, биелэлтийн талаар хариу мэдэгдэх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Шуурхай мэдээллийн алба, Засгийн газрын Шуурхай жижүүрт мэдэгдэх;

2.1.2. газар хөдлөлтийн бүс нутаг, хамарсан хүрээ, хүчийг Одон орон, геофизик судалгааны төвөөс тодотгон, цагийн байдлыг удирдлагад илтгэж, үүргээ тодруулах;

2.1.3. нэрвэгдэгсдийг эрж олох, аврах, эмнэлгийн тусламж үзүүлэх ажилд оролцож байгаа онцгой байдлын албаны хүч хэрэгсэл, гамшгаас хамгаалах улсын албадтай байнгын холбоонд орж, ослын голомтод очсон цаг хугацаа, хүч хэрэгсэл, бүрэлдэхүүн, гүйцэтгэж байгаа ажлын тухай мэдээллийг авч нэгтгэх;

2.1.4. газар хөдлөлтийн аюулын бүсийн төв, хамарсан хүрээ, учирсан хохирол, тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг тойм зурагт оруулж, удирдлагад илтгэх;

2.1.5. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс үзүүлж байгаа тусламжийн тухай мэдээллийг нэгтгэх.

2.2. Их цас, зуд, хүчтэй салхи, цасан болон шороон шуурганы үед

2.2.1. цас, зудын нөхцөл байдал, цаг агаарын аюулт үзэгдлийн талаарх мэдээг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, гамшгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж болон шуурхай удирдлага, зохицуулалтын нэгжийн дарга, холбогдох албан тушаалтан (мэргэжилтэн), улсын алба (байгууллага)-д илтгэж, өгсөн үүргийг гүйцэтгэгчид мэдэгдэж хэрэгжилтэд нь хяналт тавих, биелэлтийн талаар хариу мэдэгдэх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Шуурхай мэдээллийн алба, Засгийн газрын Шуурхай жижүүрт мэдэгдэх;

2.2.2. цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээнд тулгуурлан үнэлгээ, дүгнэлт хийж, орон нутагт хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай мэдээллийг авч, чиглэл өгөх;

2.2.3. төв, орон нутгийн мэдээллийн хэрэгсэлд “цаг агаарын аюулт үзэгдэл” “аюул” зэрэг сэрэмжлүүлэх дохиог хүн амд зарлан мэдээлэх ажил хэрхэн явагдаж байгааг Ус цаг уур, орчны шинжилгээний газар, Сурталчилгаа, мэдээллийн улсын албанаас тодруулах;

2.2.4. тухайн аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс, мэргэжлийн ангийг бэлэн байдалд оруулан ажил үүрэг гүйцэтгэх бэлтгэлийг хангуулах нэмэлт үүрэг өгөх;

2.2.5. цасанд дарагдаж хаагдсан зам, даваанд гарц гаргах, төөрсөн, сураггүй болсон хүмүүсийг эрэн хайх үүрэг бүхий мэргэжлийн алба, бүлгүүдийн томилгоог тодотгож, холбоо барих журмыг тогтоож удирдлагаар хангах;

2.2.6. Их цас, зуд, хүчтэй салхи, цасан болон шороон шуурга болсон нутгийн зааг, хэмжээ, өртсөн айл өрх, хүн, мал, амьтан, эд хөрөнгийн тухай мэдээллийг нэгтгэх;

2.2.7. их цас, цасан болон шороон шуурганд төөрсөн буюу сураггүй болсон хүмүүсийг эрж олох, аврах ажлын явц, үр дүнг тодруулах;

2.2.8. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс үзүүлж байгаа тусламжийн тухай мэдээллийг нэгтгэх;

2.2.9. их цас, зудын аюул, учирсан хохирлын тухай мэдээ, ажлын явц, үр дүнг тодорхойлж, нөхцөл байдлын тойм зурагт оруулж, орон нутгаас тавьсан хүсэлт шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлыг нэгтгэн мэдээ бэлтгэж, удирдлагад илтгэх.

2.3. Үер, усны аюулын үед

2.3.1. үерийн аюулын тухай мэдээ, цагийн байдлыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, гамшгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж болон шуурхай удирдлага, зохицуулалтын нэгжийн дарга, холбогдох албан тушаалтан (мэргэжилтэн), улсын алба (байгууллага)-д илтгэж, өгсөн үүргийг гүйцэтгэгчид мэдэгдэж хэрэгжилтэд нь хяналт тавих, биелэлтийн талаар хариу мэдэгдэх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Шуурхай мэдээллийн алба, Засгийн газрын Шуурхай жижүүрт мэдэгдэх;

2.3.2. үер, усны аюулд автагдсан нутаг дэвсгэрийг тойм зурагт тэмдэглэж, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсээс нөхцөл байдлыг тодотгон хэрэгжүүлж байгаа арга хэмжээтэй холбогдуулан удирдлагаас өгсөн үүргийг дамжуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

2.3.3. үер, усны аюул болсон аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар хэлтэс, аврах анги, отряд, салбаруудын гүйцэтгэж байгаа ажил, авсан арга хэмжээ, үр дүнг нэгтгэж, аймаг, нийслэлийн Гамшгаас хамгаалах штабаас үерийн хамгаалалтын далан, суваг, засмал замын ус зайлуулах байгууламжийн нөхцөл байдлыг тодотгож, хот тохижилтын газар, компаниудтай хамтран ажиллах үүрэг зөвлөмж өгөх;

2.3.4. үерт автагдсан нутаг дэвсгэрээс хүн, мал, эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанд аврах анги, отряд, салбар болон бусад холбогдох байгууллага, албадыг татан оролцуулах үүрэг өгөх;

2.3.5. тодорхой нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан төв, орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс үзүүлж байгаа тусламж, дэмжлэгийн тухай мэдээллийг нэгтгэх;

2.3.6. ажлын явц, үр дүн, хохирлын мэдээг нэгтгэж, цаашид авах арга хэмжээ, тулгамдсан шийдвэрлэвэл зохих асуудлыг хоногийн мэдээнд тусгаж удирдлагад илтгэх.

2.4. Ган болсон үед

2.4.1. гангийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, гамшгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж болон шуурхай удирдлага, зохицуулалтын нэгжийн дарга, холбогдох албан тушаалтан (мэргэжилтэн), улсын алба (байгууллага)-д илтгэж, өгсөн үүргийг гүйцэтгэгчид мэдэгдэж хэрэгжилтэд нь хяналт тавих, биелэлтийн талаар хариу мэдэгдэх;

2.4.2. цаг агаарын төлөв байдлын тухай мэдээллийг нэгтгэн нөхцөл байдлын тойм зурагт оруулж, цагийн байдалд үнэлгээ өгөх;

2.4.3. гамшгаас хамгаалах Хүнс, хөдөө аж ахуйн улсын албанаас тухайн орон нутгийн усны цэгүүдийн байрлал, үйл ажиллагааг тодруулах, гантай байгаа аймгийн удирдлагаас зэргэлдээх аймаг, сумдтай урьдчилан тохиролцсоноор тодорхойлсон нөөц бэлчээр, хүн, малыг нүүлгэн шилжүүлэх санал, дүгнэлтийг гаргуулж тойм зурагт тэмдэглэх;

2.4.4. гантай байгаа аймгаас хаашаа хэдэн өрх айл, хүн, мал явсныг тодотгох;

2.4.5. тодорхой нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан төв, орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс үзүүлж байгаа тусламжийн тухай мэдээллийг нэгтгэх;

2.4.6. хоногийн нөхцөл байдлын мэдээг бэлтгэж, тойм зургийн хамт удирдлагад илтгэх.

2.5. Хүний гоц халдварт өвчний үед

2.5.1. хүний гоц халдварт өвчний сэжиг илэрсэн тухай Онцгой байдлын ерөнхий газрын дарга, гамшгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж болон шуурхай удирдлага, зохицуулалтын нэгжийн дарга, холбогдох албан тушаалтан (мэргэжилтэн), улсын алба (байгууллага)-д илтгэж, өгсөн үүргийг гүйцэтгэгчид мэдэгдэж, хэрэгжилтэд нь хяналт тавих, биелэлтийн талаар хариу мэдэгдэх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Шуурхай мэдээллийн алба, Засгийн газрын Шуурхай жижүүрт мэдэгдэх;

2.5.2. аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт хүний гоц халдварт өвчний сэжиг илэрсэн тухай мэдээллийг Эрүүл мэндийн яаманд мэдэгдэх, мэргэжлийн байгууллагын үүрэг зөвлөмж өгүүлэх;

2.5.3. халдварын голомт бүхий бүс нутагт хорио цээрийн дэглэм тогтоох, 1, 2 дугаар хавьтлыг тогтоох зохион байгуулалтын арга хэмжээг авч, хүн, мал, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, халдвар эсэргүүцэх талаар орон нутгийн удирдлагаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд хяналт тавьж үүрэг, зөвлөмжөөр хангах;

2.5.4. халдварын голомтод ажиллаж байгаа хүч хэрэгслийн тооцоо, голомтын зураглалыг гаргах;

2.5.5. зэргэлдээ аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэст гоц халдварт өвчний сэжиг илэрсэн тухай мэдээлж, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг тодруулж, нэмэгдэл үүрэг өгөх;

2.5.6. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай мэдээллийг нэгтгэх;

2.5.7. ажлын явц үр дүн, цаашид авах арга хэмжээний талаар хоногийн мэдээнд тусгаж удирдлагад илтгэх.

2.6. Мал, амьдтын гоц халдварт өвчний үед

2.6.1. малын гоц халдварт өвчний сэжиг илэрсэн тухай мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, гамшгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж болон шуурхай удирдлага, зохицуулалтын нэгжийн дарга, холбогдох албан тушаалтан (мэргэжилтэн), улсын алба (байгууллага)-д илтгэж, өгсөн үүргийг гүйцэтгэгчид мэдэгдэж хэрэгжилтэд нь хяналт тавих, биелэлтийн талаар хариу мэдэгдэх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Шуурхай мэдээллийн алба, Засгийн газрын Шуурхай жижүүрт мэдэгдэх;

2.6.2. гамшгаас хамгаалах Хүнс, хөдөө аж ахуйн улсын алба, Мал эмнэлгийн газарт мэдэгдэн хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай мэдээллийг авч, хэрэгжилтэд нь хяналт тавих;

2.6.3. халдварын голомт бүхий нутаг дэвсгэрт хорио цээр тогтоох, хяналт тавих, тухайн орон нутгийн удирдлагын шийдвэрийг гаргуулах, хэрэгжилтийн явцыг тодруулах;

2.6.4. зэргэлдээ аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Онцгой байдлын газар, хэлтэст малын гоц халдварт өвчин илэрсэн тухай мэдээлэх, үүнтэй холбогдуулан хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар дүгнэлт хийж, нэмэгдэл үүрэг өгөх;

2.6.5. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай мэдээллийг нэгтгэх;

2.6.6. ажлын явц, үр дүн, цаашид авах арга хэмжээний талаар хоногийн нөхцөл байдлын мэдээ бэлтгэж тойм зургийн хамт удирдлагад илтгэх.

2.7. Ой, хөдөө аж ахуйн таримал ургамлын гоц халдварт өвчин, хортон тархсан үед

2.7.1. ой, хөдөө аж ахуйн таримал ургамлын хориот болон онц аюулт өвчин, хортон тархсан тухай мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, гамшгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж болон шуурхай удирдлага, зохицуулалтын нэгжийн дарга, холбогдох албан тушаалтан (мэргэжилтэн), улсын алба (байгууллага)-д илтгэж, өгсөн үүрэг, шийдвэрийг гүйцэтгэгчид мэдэгдэж хэрэгжилтэд нь хяналт тавих, биелэлтийн талаар хариу мэдэгдэх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Шуурхай мэдээллийн алба, Засгийн газрын Шуурхай жижүүрт мэдэгдэх;

2.7.2. тухайн бүс нутгаас амьд шавьж, мод ургамлын материал, ургамал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнээс дээж авч ургамал хорио цээрийн шинжилгээнд явуулах ажлыг зохион байгуулах талаар аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Онцгой байдлын газар хэлтэст үүрэг өгч, биелэлтийг хянаж, шинжилгээний хариуг шаардаж гаргуулах;

2.7.3. ургамлын өвчин, хортны хөнөөлийн голомтыг устгах тухай холбогдох байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

2.7.4. тархалтыг хязгаарлах, зогсоох, устгах арга хэмжээ авахад шаардлагатай тусгай зориулалтын бодис материал, техник хэрэгслээр хангах талаар мэргэжлийн байгууллага, албадаас авч байгаа арга хэмжээ, орон нутгаас авсан хүсэлтийг нэгтгэж, холбогдох албан тушаалтанд танилцуулах;

2.7.5. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай мэдээллийг нэгтгэх;

2.7.6. ажлын явц, үр дүнгийн тухай хоногийн нөхцөл байдлын мэдээнд тусгаж, тойм зурагт оруулан, удирдлагад илтгэх.

2.8. Ой, хээрийн түймэр гарсан үед

2.8.1. ой, хээрийн түймрийн тухай мэдээ, цагийн байдлыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, гамшгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж болон шуурхай удирдлага, зохицуулалтын нэгжийн дарга, холбогдох албан тушаалтан (мэргэжилтэн), улсын алба (байгууллага)-д илтгэж, өгсөн үүргийг гүйцэтгэгчид мэдэгдэж хэрэгжилтэд нь хяналт тавих, биелэлтийн талаар хариу мэдэгдэх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Шуурхай мэдээллийн алба, Засгийн газрын Шуурхай жижүүрт мэдэгдэх;

2.8.2. түймрийн мэдээг хүлээн авч, цаг агаар, газар орны нөхцөл байдалд үнэлгээ өгч, тойм зурагт тэмдэглэх;

2.8.3. түймэр гарч байгаа аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Онцгой байдлын газар, хэлтсээс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, ажиллаж байгаа хүч хэрэгслийн мэдээг тодруулж, дүгнэлт хийх, чиглэл өгөх;

2.8.4. түймэрт өртөж болзошгүй хүн, мал, өвс тэжээл, хашаа саравч байгаа эсэхийг тодотгож, аймаг, сумдын удирдлага болон холбогдох байгууллагад мэдэгдэж, арга хэмжээг зохион байгуулах талаар удирдлагаас өгсөн үүргийг тухайн аймгийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга нарт хүргэж, хэрэгжилтэд нь хяналт тавих;

2.8.5. тодорхой нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан төв, орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс үзүүлж байгаа тусламж, дэмжлэгийн тухай мэдээллийг нэгтгэх;

2.8.6. хоногийн нөхцөл байдлын мэдээ, тойм зураг бэлтгэн удирдлагад илтгэх.

2.9. Хүн ам төвлөрсөн хот суурин газар удаан хугацаагаар үргэлжилсэн гал, утаанд хүн ихээр хордож болон шатаж болох үед

2.9.1. гал түймэр гарсан тухай мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, гамшгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж болон шуурхай удирдлага, зохицуулалтын нэгжийн дарга, холбогдох албан тушаалтан (мэргэжилтэн), улсын алба (байгууллага)-д илтгэж, өгсөн үүрэг, шийдвэрийг гүйцэтгэгчид мэдэгдэж хэрэгжилтэд нь хяналт тавих, биелэлтийн талаар хариу

мэдэгдэх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Шуурхай мэдээллийн алба, Засгийн газрын Шуурхай жижүүрт мэдэгдэх;

2.9.2. түймэр унтраах үйл ажиллагаа болон түймрийн нөхцөл байдалд үнэлгээ өгч, аврах, гал унтраах анги, бүлгүүдийг ажиллуулж, үүрэг гүйцэтгэлд нь хяналт тавих;

2.9.3. нутгийн захиргааны байгууллага болон түймэр гарсан газрын харьяалах дээд байгууллагаас мэдээлэл авч нөхцөл байдлыг тодруулах;

2.9.4. гал түймэрт өртсөн хүн, мал, амьтан, ургамал, эд хөрөнгийн хохирлын тухай мэдээллийг нэгтгэх;

2.9.5. гал түймрийг унтраах үйл ажиллагаанд шаардагдах нэмэлт хүч, хэрэгсэл, гал унтраах усны эх үүсвэрийн найдвартай байдал, хангалт үйлчилгээний талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах;

2.9.6. гал түймэр гарсан нутаг дэвсгэрт хүн, автомашины хөдөлгөөнийг хязгаарлах, гал түймэр гарсан шалтгаан нөхцөлийг тогтоолгохоор хууль хяналтын байгууллагад мэдэгдэх, мөрдөн байцаагч, галын шинжээч зэрэг мэргэжлийн ажилтнуудыг татан оролцуулах;

2.9.7. ажлын явц, үр дүнг нэгтгэж, цаашид авах арга хэмжээний тухай хоногийн мэдээнд тусгаж, удирдлагад илтгэх.

2.10. Үйлдвэрлэлийн болон зам, тээврийн хэрэгслийн осол сүйрлийн үед

2.10.1. үйлдвэрлэлийн болон тээврийн хэрэгслийн осол, сүйрэл болсон тухай мэдээг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, гамшгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж болон шуурхай удирдлага, зохицуулалтын нэгжийн дарга, холбогдох албан тушаалтан (мэргэжилтэн), улсын алба (байгууллага)-д илтгэж, удирдлагаас өгсөн үүрэг, шийдвэрийг гүйцэтгэгчид мэдэгдэж хэрэгжилтэд нь хяналт тавих, биелэлтийн талаар хариу мэдэгдэх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Шуурхай мэдээллийн алба, Засгийн газрын Шуурхай жижүүрт мэдэгдэх;

2.10.2. үйлдвэрлэлийн болон тээврийн хэрэгслийн осол, сүйрэл болсон тухай мэдээллийг холбогдох улсын албад, албан тушаалтанд мэдээлэх;

2.10.3. осол, сүйрэл болсон газрын нөхцөл байдлыг тодотгох, осол сүйрлийн хохирлын урьдчилсан мэдээллийг холбогдох улсын албадаас авч нэгтгэх;

2.10.4. осол, сүйрлийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс, мэргэжлийн албадыг татан оролцуулах, аврах ажилд шаардагдах хүн хүч, техник багаж хэрэгслэлээр хангах ажлыг тодотгох, улсын албадыг оролцуулах;

2.10.5. нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох, зам, гүүр, төмөр зам, онгоцны буудлын хэвийн үйл ажиллагааны талаар холбогдох арга хэмжээг удирдлага зохицуулалтаар хангах;

2.10.6. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс үзүүлж байгаа тусламжийн тухай мэдээллийг нэгтгэх;

2.10.7. аврах, хор уршгийг арилгах ажлын явц, үр дүнг нэгтгэж, хоногийн нөхцөл байдлын мэдээнд тусгаж, удирдлагад илтгэх.

2.11. Цацраг, химийн хорт бодис алдагдсан үед

2.11.1. цацраг, химийн хорт бодис алдагдсан тухай мэдээг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, гамшгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж болон шуурхай удирдлага, зохицуулалтын нэгжийн дарга, холбогдох албан тушаалтан (мэргэжилтэн), улсын алба (байгууллага)-д илтгэж, өгсөн үүргийг гүйцэтгэгчид мэдэгдэж, хэрэгжилтэд нь хяналт тавих, биелэлтийн талаар хариу мэдэгдэх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Шуурхай мэдээллийн алба, Засгийн газрын Шуурхай жижүүрт мэдэгдэх;

2.11.2. ослын голомтод ажиллаж байгаа цацраг, химийн хорт бодисыг илрүүлэх, хоргүйжүүлэх аргачлалыг тодотгох, цацраг химийн хордолтыг саармагжуулах үүрэг бүхий цацраг, химийн шинжилгээний шуурхай бүлэгтэй байнгын холбоонд орж мэдээ, мэдээлэл солилцох, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

2.11.3. цагийн байдалд үнэлгээ хийхэд цаг уурын байдлыг харгалзах, хордолт тархах гүн, эзлэх талбай, хил хязгаарыг тодорхойлох, хүн амын байршил, нягтралыг тогтоож тойм зурагт тэмдэглэх;

2.11.4. цацраг, химийн хордолтын цагийн байдалд урьдчилсан үнэлгээ хийж, болзошгүй хордолтын бүсийн хэмжээ, цаашид тархаж болзошгүй газар нутгийн хил хязгаар, хүн амын байршил, нягтралыг урьдчилсан байдлаар тогтоох;

2.11.5. шаардлагатай хүч хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, бодис, уусмалын нөхөн хангалтад тодотгол хийх;

2.11.6. цацраг, химийн хордолтын хор уршгийг арилгах ажлын явц, үр дүнг нэгтгэн цаашид авах арга хэмжээний тухай хоногийн нөхцөл байдлын мэдээнд тусгаж, тойм зургийн хамт удирдлагад илтгэх.

2.12. Алан хядах ажиллагаа, дэлбэрэлт болсон үед

2.12.1. алан хядах ажиллагаа, дэлбэрэлт болсон тухай мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, гамшгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж болон шуурхай удирдлага, зохицуулалтын нэгжийн дарга, холбогдох албан тушаалтан (мэргэжилтэн), улсын алба (байгууллага)-д илтгэж, өгсөн үүргийг гүйцэтгэгчид мэдэгдэж хэрэгжилтэд нь хяналт тавих, биелэлтийн талаар хариу мэдэгдэх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Шуурхай мэдээллийн алба, Засгийн газрын Шуурхай жижүүр, Тагнуулын ерөнхий газарт мэдэгдэх;

2.12.2. Тагнуулын ерөнхий газар, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газраас цагийн байдлыг тодруулах;

2.12.3. Зэвсэгт хүчин болон хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, Онцгой байдлын ерөнхий газрын харъяа салбар, нэгжийг тусгай зааврын дагуу бэлэн байдалд оруулах, харуул хамгаалалтыг хүч нэмэгдүүлэх, үүрэг, зөвлөмж өгөх;

2.12.4. алан хядах, дэлбэрэлт болсон газрын цагийн байдлыг тодотгох, алан хядах, дэлбэрэлтийн хамарсан хүрээ, хохирлын урьдчилсан мэдээллийг авах, нөхцөл байдлыг удирдлагад илтгэж, өгсөн үүргийг гүйцэтгэгчид хүргэж, хэрэгжилтэд нь хяналт тавих;

2.12.5. алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн хүч хэрэгсэл, мэргэжлийн албадыг татан оролцуулах, аврах ажилд шаардагдах хүн хүч, техник багаж хэрэгслээр хангах ажлыг холбогдох яам, агентлаг, улсын албадаас шаардах;

2.12.6. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай мэдээллийг нэгтгэх;

2.12.7. нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох, зам, гүүр, төмөр зам, онгоцны буудлын хэвийн үйл ажиллагааг хангах талаар холбогдох улсын албаны хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үр дүнгийн талаарх мэдээллийг авч нэгтгэх;

2.12.8. аврах, хор уршгийг арилгах ажлын явц, үр дүнг нэгтгэж, цаашид авах арга хэмжээний тухай хоногийн нөхцөл байдлын тухай мэдээнд тусгаж танилцуулах.

ооо

ШУУРХАЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОМИЛГОО

1. Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт болох үед ажиллах бүрэлдэхүүн:

-Гамшигтай тэмцэх газрын дарга /ажлын хэсгийн ахлагч/

-мөн газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах шуурхай удирдлагын хэлтсийн дарга /ажлын хэсгийн дэд ахлагч/

-Бодлогын хэрэгжилтийг зохицуулах шуурхай удирдлагын хэлтсийн дэд бүтэц, газар хөдлөлтийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

-мөн хэлтсийн хөдөө аж ахуйн гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

-мөн хэлтсийн цаг уур, экологийн асуудал хариуцсан мэргэжилтэн

-мөн хэлтсийн нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн

-мөн хэлтсийн аврах ажлын технологи, аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

-Улсын нөөц, сэргээн босголтын газрын Нөөцийн хэлтсийн үр тарианы нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

-мөн газрын Нөөцийн хэлтсийн өвс тэжээлийн нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Хүн, мал, амьтан, ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах үед ажиллах бүрэлдэхүүн:

-Гамшигтай тэмцэх газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах шуурхай удирдлагын хэлтсийн дарга /ажлын хэсгийн ахлагч/

-мөн хэлтсийн хүн амыг гамшгаас хамгаалах бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн

-мөн хэлтсийн хөдөө аж ахуйн гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

-мөн хэлтсийн хүний гоц халдварт өвчнөөс хамгаалах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

-мөн хэлтсийн мал, амьтны гоц халдварт өвчнөөс хамгаалах асуудал хариуцсан мэргэжилтэн

-Улсын нөөц, сэргээн босголтын газрын Нөөцийн хэлтсийн үйлдвэрлэл, техник, өргөн хэрэглээний барааны нөөц хариуцсан мэргэжилтэн

3. Ой, хээрийн түймэр болон хүн ам төвлөрсөн хот суурин газар удаан хугацаагаар үргэлжилсэн гал, утаанд хүн ихээр хордож болон шатаж болох үед ажиллах бүрэлдэхүүн:

-Гал түймэртэй тэмцэх газрын дарга /ажлын хэсгийн ахлагч/

-мөн газрын Гал түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хяналтын хэлтсийн дарга /ажлын хэсгийн дэд ахлагч/

-Гал түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хяналтын хэлтсийн улсын онц чухал болон галын аюултай объект хариуцсан ахлах мэргэжилтэн

-мөн хэлтсийн гал унтраах бэлтгэл, бэлэн байдал хариуцсан мэргэжилтэн

-мөн хэлтсийн ой, хээрийн түймэр хариуцсан мэргэжилтэн

-Гамшигтай тэмцэх газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах шуурхай удирдлагын хэлтсийн хүн амыг гамшгаас хамгаалах бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн

4. Үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж, шугам сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдсан үед ажиллах бүрэлдэхүүн:

-Гамшигтай тэмцэх газрын дарга /ажлын хэсгийн ахлагч/

-мөн газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах шуурхай удирдлагын хэлтсийн дарга /ажлын хэсгийн дэд ахлагч/

-Бодлогын хэрэгжилтийг зохицуулах шуурхай удирдлагын хэлтсийн дэд бүтэц, газар хөдлөлтийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

-мөн хэлтсийн нөхцөл байдлын мэдээ, мэдээлэл, оператив ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

-мөн хэлтсийн гамшгаас хамгаалах улсын хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн

-мөн хэлтсийн цацраг, химийн хордолтоос хамгаалах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

-мөн хэлтсийн химийн хорт бодисын аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

-Улсын нөөц, сэргээн босголтын газрын Нөөцийн хэлтсийн үйлдвэрлэл, техник, өргөн хэрэглээний барааны нөөц хариуцсан мэргэжилтэн

5. Алан хядах ажиллагаа, дэлбэрэлт болсон үед ажиллах бүрэлдэхүүн:

-Гамшигтай тэмцэх газрын дарга /ажлын хэсгийн ахлагч/

-мөн газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах шуурхай удирдлагын хэлтсийн дарга /ажлын хэсгийн дэд ахлагч/


-Бодлогын хэрэгжилтийг зохицуулах шуурхай удирдлагын хэлтсийн нөхцөл байдлын мэдээ, мэдээлэл, оператив ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

-мөн хэлтсийн тэсэрч, дэлбэрэх бодисоос хамгаалах асуудал хариуцсан мэргэжилтэн

-мөн хэлтсийн аврах ажлын технологи, аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

oOo

ГАМШГИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ БҮДҮҮВЧ



ШУУРХАЙ АЖИЛЛАГААНД ХӨТЛӨГДӨХ БАРИМТ БИЧИГ

а/ Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн:

1. Ажлын дэвтэр
2. Хоногийн нөхцөл байдлын мэдээ
3. Яаралтай цугларах дохиогоор ажилласан тэмдэглэл, ирцийн бүртгэл
4. Хойшлуулшгүй яаралтай ажлын томилолт олгосон тухай тэмдэглэл
5. Хойшлуулшгүй яаралтай ажлын томилолтын мөнгө олгосон тухай баримт
6. Монгол Улсын гамшгийн нөхцөл байдлын зураг
7. Нийслэл Улаанбаатар хотын бүдүүвч зураг
8. Өдөр тутмын болон долоо хоногийн цаг агаарын мэдээ
9. Бие бүрэлдэхүүний хаяг, байрлалын бүдүүвч
10. Шуурхай ажил /жижүүр/-ын автомашины ашиглалтын бүртгэл

б/ Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн туслах-шуурхай удирдлагын операторын:

1. “Цонхлон” радио станцын ажлын дэвтэр
2. Хүлээн авсан мэдээний дэвтэр
3. Явуулсан мэдээний дэвтэр
4. Хүч хэрэгслийн хоногийн мэдээний хуудас
5. Гамшиг, ослын дуудлагын дэлгэрэнгүй бүртгэлийн дэвтэр
6. Иргэдээс ирүүлсэн мэдээллийн бүртгэл

*Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2008 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн
286 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

**ШУУРХАЙ УДИРДЛАГЫН ЕРӨНХИЙ ЗОХИЦУУЛАГЧИЙН
АЖЛЫН БАЙРАНД БАЙХ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ**

а/ Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль
2. Галын аюулгүй байдлын тухай хууль
3. Шуурхай ажиллагааг зохион байгуулах журам
4. Шуурхай удирдлагын жижүүрийн ажиллах заавар
5. Яаралтай цугларах дохиогоор ажиллах журам
6. Хойшлуулшгүй яаралтай ажлын үед албан томилолт олгох журам
7. Улсын онцгой комиссын гишүүдийн утасны жагсаалт
8. Гамшгаас хамгаалах улсын албад, яам, агентлагийн утасны жагсаалт
9. Онцгой байдлын ерөнхий газар, харъяа салбар, нэгжийн албан тушаалтнуудын утасны жагсаалт
10. Бусад гарын авлага

**б/ Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн туслах-шуурхай
удирдлагын операторын:**

1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын холбоо зохион байгуулж, ашиглах журам
2. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулах заавар
3. Томилогдсон бүлгийн холбооны техник хэрэгсэл ашиглалтын журам, заавар
4. Холбооны техник хэрэгслийн техникийн өгөгдөхүүн, ашиглалтын заавар

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2008 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн
286 дугаар тушаалын 7 дугаар хавсралт

ШУУРХАЙ АЖИЛЛАГААНД АШИГЛАХ ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

а/ Суурин буюу ажлын байранд байх

№	Техник хэрэгслийн нэр		Тоо хэмжээ	Зориулалт
1	Barret богино долгионы радио станц		1	Аймгийн ОБХ-үүдтэй өдөр тутам холбоо хангана.
2	Радио модем		1	Дотоод сүлжээнд холбогдож радиогоор өгөгдөл дамжуулна.
3	Хэт богино долгионы радио станц		1	Хот дотор салбаруудтай холбоо хангана.
4	Телефон аппарат Төрийн холбоо- 263554 “МЦХ” АТС -325726		2	Өдөр тутмын мэдээ, мэдээллийг солилцоно.
5	Факс		1	Шаардлагатай мэдээ, мэдээллийг цаасан хэлбэрээр солилцоно.
6	Компьютер	ажлын компьютер	2	Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн хоногийн нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг боловсруулна.
		хяналтын	1	Хянах
7	Хэвлэгч (хар, цагаан)		1	Боловсруулсан мэдээллийг хэвлэнэ.
8	Хэвлэгч, хувилагч (өнгөт)		1	Шаардлагатай мэдээллийг олшруулна. Зарим цаасан мэдээллийг хөрвүүлнэ.
9	Зөөврийн бичил диск (1Gb багтаамжтай)		4	Мэдээ, мэдээллийг зөөвөрлөхөд хэрэглэнэ
10	LCD дэлгэц	кабелийн ТВ	1	Мэдээ, мэдээлэл үзнэ.
		мэдээлэл	1	
		цаг агаарын мэдээлэл	1	Цаг агаарын мэдээллийг тасралтгүй авна.
11	Цахилгаан баригч UPS		1	Цахилгааны саатлын үед ашиглана.
12	Цахилгаан үүсгүүр		1	Цахилгааны саатлын үед ашиглана.
13	Проектор		1	Бэлтгэсэн мэдээллийг дэлгэцэнд үзүүлнэ.
14	Зөөврийн дэлгэц		1	
15	Интернет		24 цагаар тасралтгүй интернетэд холбогдоно.	
16	Мэдээллийн сан		цогц	Шаардлагатай мэдээллийн санг ашиглана.
17	Төмөр шүүгээ		1	Зөөврийн мэдээллийн хэрэгслийг хадгална.

б/ Зөөврийн буюу шуурхай ажлын хэсэг ашиглах

№	Техник хэрэгслийн нэр		Тоо хэмжээ	Зориулалт
1	Хэт богино долгионы гар радио станц		5	Ажлын хэсгийн бүрэлдэхүүний дотоод холбоо хангана.
2	Сансрын холбооны утас Дугаар: 881641462947 881641462938		2	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хөдөө орон нутагт ажиллах үед телефон холбоо хангана.
3	Байршил тодорхойлогч		1	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн ашиглана.